*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн*
*Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн*
*дэд профессор, цагдаагийн хурандаа Д.Мөнхбаяр*

# НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН МАНДАТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны гишүүнчлэл нь зэвсэгт мөргөлдөөн бүхий бүс нутагт асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлсон аюулгүйн зөвлөлийн мандатад үндэслэгдэнэ. Сүүлийн 10 жилд энэхүү ажиллагаа нь сөргөлдөгч талыг тусгаарлаж үйл ажиллагаанд нь хяналт тавих хэлбэрээр явагддаг байсан уламжлалт хандлагаас энхийг сахиулах олон талт хамтын ажиллагаа болж өргөжсөн. Уг ажиллагааны зорилт нь:

1. Энхийн гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд туслах;
2. Сөргөлдөгч талын асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, улс төрийн зөвшилцөл хийх боломжийг олгох зорилгоор гал зогсоох;
3. Талуудыг энгийн амьдралд шилжүүлэх талаар ухуулан сурталчилж аюулгүй орчныг бий болгох;
4. Сөргөлдөгч талыг хоёр талд хувааж хил тогтоох, сөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх;
5. Эдийн засгийн хөгжил болон сайн засаглал ардчилалын зарчимд тулгуурлан тэргүүлэгч орнуудын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх хөдөлгөөнийг тогтмолжуулах замаар засаглалын тогтвортой байдлыг хангах;
6. Дамжин өнгөрүүлэх хөдөлгөөний тоггвортой явуулах зорилгоор нутаг дэвсгэрт захиргааны хяналтыг тогтоож ингэснээр тухайн улсын засгийн газрыг хэвийн хэмжээнд ажиллах боломжоор хангахад бүхий л нөхцөлөөр туслах.

Энхийг сахиулах ажиллагааны нэгдсэн удирдлага нь Аюулгүйн зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд ерөнхий нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээнд багтана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь энхийг сахиулах ажиллагааны удирдлага зохион байгуулалт үйл ажиллагааг хариуцуулахаар энхийг сахиулах ажиллагааны ерөнхий нарийн бичгийн даргыг томилно.

Ерөнхий нарийн бичгийн дарга нь аюулгүйн зөвлөлийн зөвшөөрлөөр өөрийн тусгай бие төлөөлөгчийг томилох бөгөөд уг этгээд нь

мандатын дагуу тавигдсан зорилтыг бислүүлэх үүрэг хүлээж ажиллагааг удирдан зохион байгуулна.

Тусгай бие төлөөлөгч нь тавигдсан зорилтыг хангахын тулд гишүүн орнуудын бие бүрэлдэхүүнийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамруулж энхийг сахиулах ажиллагааны ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлуулан НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргад уламжилна.

Тусгай бие төлөөлөгчийн /ТБТ-SRSG/ төлөөлөгч нь дараах үүрэгтэй.

1. Улс төрийн үйл явцыг дэмжих;
2. НҮБ-ын оролцоог тэргүүлэх;
3. Тавигдсан зорилтыг хангахад тэргүүлэх;
4. Түр засгийн газрыг тэргүүлэх

ТБТ /SRSG/ үүрэг зорилтыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах тайлбарлан таниулах үүрэг хүлээнэ. ТБТ нь тавигдсан зорилтыг биелүүлэх зорилгоор гишүүн орнуудын цагдаа, цэргийн алба хаагчдад заавар чиглэл өгч нэгдсэн удирдлагаар хангана. Түүнчлэн тавигдсан зорилго зорилтыг хангахын тулд удирдлагын мэргэшсэн багтай нягт хамтран ажиллаж төлөвлөгөө болон түүний хэрэгжилтыг боловсронгуй болгох зорилгоор идэвхи санаачлагатай ажиллана.

Захиргааны удирдлагын газрын дарга буюу захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх албан тушаалтан нь НҮБ-ээс гаргасан эрх зүйн хэм хэмжээний хүрээнд үүрэг зорилтыг хэрэгжүүлэх ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах, захиргааны удирдлага болон дэмжлэгийг үзүүлэхэд ТБТ-д туслах үүрэг хүлээнэ. Мөн үйл ажиллагаанд холбоотой ерөнхий болон техникийн үйлчилгээг үзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд тавигдсан зорилтыг биелүүлэх ажиллагаатай холбоотой, захиргааны удирдлагтай холбоотой ар талын хангалт үйлчилгээний асуудлыг хариуцан шийдвэрлэж үйл ажиллагааны бие даасан байдлыг хангана. Зэвсэгт хүчний командлагч нь зэвсэгт хүчний талаар ТБТ-д хариуцсан чиглэлээр зөвлөх үүрэг хүлээх ба тэрээр цэргийн анги байгууллага, цэргийн ажиглагч бие бүрэлдхүүний үйл ажиллагаанд хяналт тавина.

Цагдаагийн дарга /ЦД/ буюу цагдаагийн ахлах зөвлөх /ЦАЗ/ нь НҮБ-ын гишүүн орнуудаас үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн үүрэгтэй холбоотой бүхий үйл ажиллагааг цагдаагийн нэгж, анги байгууллага хаана үүрэг гүйцэтгэж байгаагаас үл хамаарч нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

Өгөгдсөн үүрэг зорилтоос хамаарч ЦАЗ нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад ардчилалыг дэмжих, олон нийтийн цагдаагийн

үйл ажиллагаа, байгууллагын шинэчлэл ба алба хаагчдыг сонгох, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөх болон хяналтын үүрэг гүйцэтгэнэ.

Косово болон Зүүн Тимор гэх мэт улс орнуудад цагдаагийн үйл ажиллагаа явуулж буй алба хаагдад тухайн бүс нутагт хууль сахиулах үйл ажиллагаа явуулах нэмэлт үүрэг хүлээж байсан.

**Энхийг сахиулах ажиллагааны газар.** Аюулгүйн зөвлөл нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг эхлүүлэх болон дуусгавар болгох эрх эдэлнэ.

Энхийг дэмжих ажиллагааны удирдлагыг Аюулгүйн зөвлөлийн олгосон эрх хэмжээний хүрээнд Ерөнхий нарийн бичгийн дарга хэрэгжүүлнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга энхийг сахиулах ажиллагааны ерөнхий нарийн бичгийн даргад тухайн ажиллагааны удирдлага зохион байгуулалт, бэлтгэл, төлөвлөлт, хэрэгжилтийг хариуцуулахаар эрхээ шилжүүлж болно.

Энхийг сахиулах ажиллагааны газар нь Аюулгүйн Зөвлөл, Ерөнхий Ассамблейд өөрийн хариуцсан бие даасан үйл ажиллагааны талаар туслалцаа үзүүлэх бөгөөд энхийг сахиулах ажиллагааны тусгай хороонд нэг ёсондоо нарийн бичгийн үйлчилгээг үзүүлнэ.

**Энхийг сахиулах ажиллагааны газар /ЭСАГ/-ын үүрэг.** ЭСАГ нь олон улсын энх тайван аюулгүй байдлыг сахин хамгаалахад Ерөнхий нарийн бичгийн дарга болон гишүүн орнуудад туслах үүрэг хүлээнэ.

ЭСАГ нь Аюулгүйн Зөвлөл болон Ерөнхий Ассамблейн ерөнхий, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын шууд удирдлага дор тавигдсан үүрэг зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор энхийг сахиулах үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, удирдах, дэмжих болон зохицуулах үүрэг хүлээнэ.

ЭСАГ нь захиргааны удирдлагын болон нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэх ар талын хангалтыг хамгийн бага зардлаар боломжит хувилбараар хэрэгжүүлэхийг эрхэмлэж ажиллана. Энэ нь цаг үеэ олсон чанартай үйлчилгээ ба тоног төхөөрөмж авах, тэдгээрийн ашигт үйлийн коэффицент өндөр байх, санхүүгийн боломжит нөөц, сайтар бэлтгэгдсэн алба хаагчдыг хамруулах явдлаар тодорхойлогдоно.

Түүнчлэн НҮБ ын энхийн болон улс төрийн бусад үйл ажиллагаанд цэрэг, цагдаа, тэсэрч дэлбэрэх бодис, галт зэвсгийн аюулгүй ажиллагаа, ар талын болон захиргааны удирдлагын чиглэлээр зааварчлага өгч туслалцаа үзүүлнэ.

Хуурай газарт явагдаж буй бие даасан энхийг сахиулах ажиллагаа нь улс төрийн үйл явцад шууд нөлөөлөх гуравдагч тал болсон НҮБ-ын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилготой. Энэхүү зорилтыг хангахын

тулд ЭСАГ нь шаардлагатай нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй энхийг сахиулагч нарын аюулгүй байдлыг хангах, эрсдлийг бууруулах зорилтыг хангаж ажиллана.

**ЭСАГ-ын бүтэц, зохион байгуулалт:**

1. Энхийг сахиулах ажиллагааны ерөнхий нарийн бичгийн даргын алба
2. Ажлын алба
3. Үйл ажиллагааны газар
4. Дэмжлэг үзүүлэх газар
5. Цэргийн хэлтэс
6. Цагдаагийг хэлтэс
7. Энхийг сахиулах тэргүүн туршлага нэвтрүүлэх нэгж
8. Тэсэрч дэлбэрэх бодисын аюулгүй ажиллагааг хангах үйлчилгээ.

**Энхийг сахиулах ажиллагааны ерөнхий нарийн бичгийн даргын алба.** Уг алба нь энхийг сахиулах ажиллагааны ерөнхий нарийн бичгийн даргад стратеги бодлого төлөвлөлтийн нэмэлт зөвлөгөө өгөх болон албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй. Мөн албаны харилцаа холбооны стратегийг удирдан зохион байгуулж энхийг сахиулах ажиллагааны ерөнхий нарийн бичгийн даргад харъяа нэгж байгууллагын хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх, НҮБ-ын гишүүн орнууд болон тус байгууллагын бусад алба, нэгжтэй хамтран ажиллах стратеги болон аргачлалыг боловсруулдаг.

**Ажлын алба** нь ЭСАГ-ын хүний нөөц, санхүү, захиргааны удирдлагын асуудлыг хариуцан шийдвэрлэх бөгөөд үүнд ажлын байрыг ангилах, ажилтан сонгон шалгаруулах, алба хаагчийг байршуулах, албан тушаалд томилох, зөвлөх, болон хүний нөөцийн менежментийг хэрэгжүүлнэ. Мөн байгууллагын санхүү төсвийн удирдлагагыг хэрэгжүүлж тайлагнана. Эцэст нь төв байран дахь албан хэрэгцээний тоног төхөөрөмж, эд хэрэгсэл, албан өрөөний хувиарлалт зэргийг хариуцан шийдвэрлэнэ.

**Үйл ажиллагааны газар** энхийг сахицулах ажиллагааны зорилтыг хангахын тулд тэргүүлэх улс төрийн болон үйл ажиллаганы төлөвлөгөөг боловсруулж түгээнэ. Аюулгүйн Зөвлөлд танилцуулах НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын тайлан илтгэлийг боловсруулах, НҮБ-ын төв штаб болон нутаг дэвсгэрт явагдаж буй үйл ажиллагаанд зориулан газрын зургийг дижитал болон бусад байдлаар бэлтгэнэ. Мөн үйл ажиллагааг хянаж, энхийг сахиулах ажиллагаа явагдаж буй бүхий л нутаг дэвсгэрээс мэдээллийг нэгтгэн боловсруулж эрсдлийн үнэлгээг тодорхойлно.

**Дэмжлэг үзүүлэх газар** энхийг сахиулах ажиллагааны тасралтүй шуурхай байдлыг хангах зорилгоор ар тал, санхүү, хангамжийн удирдлага зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ. Уг үүрэгт нь хүний нөөцийн менежментийн бодлого, зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлаагтай төсөв хөрөнгийн төлөвлөх, зарцуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, тоног. төхөөрөмж ар талын үйлчилгээтэй холбоотой бодлогын хэрэгжилт, хяналтын үйл ажиллагаа хамаарна.

**Цэргийн хэлтэс** энхийг сахиулах зорилгыг биелүүлэх ажилллагаанд оролцож буй цэргийн анги байгууллагын үйл ажиллагааны стратеги, үзэл баримтлалыг хөгжүүлэх болон ЭСАГ-ыг цэргийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

**Энхийг сахиулах тэргүүн туршлага нэвтрүүлэх нэгж** НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны үр дүн, амжилт, дутагдалд дүн шинжилгээ хийж үнэлэлт өгнө. Дүн шинжилгээнд үндэслэн тэргүүн туршлага, шинэ санааг гаргаж үйл ажиллагаа болон ирээдүйд хийж гүйцэтгэх ажиллагааны төлөвлөгөө менежментийг боловсронгүй болгох зөвлөмж боловсруулна. Энэхүү нэгж нь мөн 4 дүгээр хороо /Тусгай улс төрийн болон колончлолын бус/ болон Энхийг сахиулах ажиллагааны тусгай хороонд туслах үүрэг хүлээдэг.

**Тэсэрч дэлбэрэх бодисын аюулгүй ажиллагааг хангах үйлчилгээ.Уг** алба нь хуурай газарт тэсэрч дэлбэрэх бодисын аюулгүй байдлын сэрэмжийг нэмэгдүүлэх ЭСАГ-ын үйл ажиллагааг тухайн газар нутагт тэсэрч дэлбэрэх бодисын аюулгүй байдлыг хангах замаар дэмжиж ажиллана. Энэхүү үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ минжүүлсэн талбайн эрсдлийн үнэлгээг хийж хяналт тавьж хохирогч нарт зөвлөх, тусламж үзүүлэх үйлчилгээг эрхлэх болон тэсэрч дэлбэрэх бодисын аюулгүй ажиллагаатай холбоотой стандартыг хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэнэ. Уг ажиллагааг тэсэрч дэлбэрэх бодисын цахим мэдээллийн сүлжээ буюу E-MINE ашиглаж үйлдэнэ.

НҮБ-ын Цагдаагийн алба нь Нэгдсэн үндэстэний байгууллагын олон улсад цагдаагийн байгуулага болон энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цагдаагийн бие бүрэлдхүүнд зөвлөгөө, эрхэлж буй үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлдэг. Тус цагдаагийн алба нь дэлхий дахинд 13 төрлийн энхийг сахиулах цагдаагийн ажиллагаа явуулдаг.

Одоогийн байдлаар олон улсаас уг үйл ажилагаанд өөрийн улс орондоо туршлага хуримтлуулсан олон мянган цагдаагийн алба хаагч нарыг татан оролцуулсан.

НҮБ-ын Цагдаагийн алба хаагч нар нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй нэгжийн бүтэц зохион байгуулалт, дадлага сургалт, халамжлан

хүмүүжүүлэх /үүрэгт ажилд нь мэргэшүүлэх/, чиглэлээр мэргэжлийн шинжээч нарын зөвлөгөөг өдөр бүр өгсөөр ирсэн.

Цагдаагийн алба нь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын үндсэн зохион байгуулах нэгж юм. Цагдаагийн үйл ажиллагааг Цагдаагийн зөвлөх гардан зохион явуулах ба энхийг сахиулах үйл ажиллагааны тайланг энхийг сахиулах ажиллагаа эрхэлсэн Ерөнхий нарийн бичгийн даргад шууд мэдээлнэ. Цагдаагийн зөвлөх нь ял эдлүүлэх, шүүн таслах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, бодлогын хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгавартай холбоотой асуудлаар Ерөнхий нарийн бичгийн дарга болон нарийн бичгийн дарга нарын ажлын албаны энхийг сахиулах ажиллагаа эрхэлсэн албан тушаалтан нарыг бодитой мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлдэг.

Цагдаагийн алба нь өөрийн алба хаагчдаа гишүүн орнуудын цагдаагийн байгууллага төдийгүй энгийн иргэдийг тодорхой хугацаагаар томилж, чөлөөлөх замаар элсүүлэн ажиллуулдаг.

- Цагдаагийн Зөвлөхийн ажлын алба
- Бодлого төлөвлөлтийн хэлтэс
- Сургалт, хөгжлийн хэлтэс
- Ажиллагааны удирдлагын хэлтэс

**Цагдаагийн Зөвлөхийн ажлын алба** нь дэлхий нийтэд явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цагдаагийн албаны бодлого. үйл ажиллагаанд суурилсан стратеги, зааварчлага болон нэгдсэн удирдлагаар хангах үүргийг хүлээдэг. Энэхүү стратегийг хамтын ажиллагаатай гишүүн орнууд, НҮБ-ын бусад газар, хэлтэс, бүсийн болон бүс нутгийн салбар байгууллагууд, их сургуулиуд, судалгаа, шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран боловсруулдаг. Мөн алба нь Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба, Төв байр хооронд мэдээлэл солилцох, мэдээллийн технологи ашиглахтай холбоотой асуудлыг зохицуулах үүрэгтэй.

**Бодлого төлөвлөлтийн хэлтэс** нь НҮБ-ын Цагдаагийн албаны хэрэгжүүлэх асуудлын хүрээнд зөрчилдөөнтэй хамаарах асуудал, энхийг сахиулах, энх тайван байдлыг бий болгох ажиллагааг өөрийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлдэг. Хэрэгжүүлэх асуудлын хүрээнд НҮБ-ын Цагдаагийн албаны шинэ ажиллагааны хийж гүйцэтгэх даалгавар, үйл ажиллагааг төлөвлөх, бүрэлдхүүнд оруулж мандатаар хэрэгжүүлэх, ажиллагааны үзэл санааг боловсруулах үүрэг хүлээдэг. Хэлтэс нь мөн НҮБ-ын цагдаагийн албаны бие бүрэлдэхүүний үйл ажиллагаа, ажиллагааны гүйцэтгэлийн нарийвчилсан удирдамжыг шинэчилж байх, захиалгат болон төлөвлөгөөт сургалтыг тасралтгүй зохион байгуулдаг.

1960 оноос НҮБ-ын цагдаа энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож эхэлсэн бөгөөд 1990 оноос үйл ажиллагаа нь эрчимжсэн.Одоогоор НҮБ-ын цагдаа дэлхийн 13 оронд 15000 орчим цагдаагийн алба хаагч орлцож энхийг сахиулж байна. Тэднийг НҮБ-аас томилогдсон тусгай сургагч багш Англи, Франц хэлний мэдлэг, жолоодлогын ур чадвар, хурдан буудлагын ур чадвар, компьютерийн мэдлэгийг нь тусгай шалгуур үзүүлэлтээр шалгаруулж сонгодог.

2016 онд ЦЕГ даргын 6/76 тоот тушаалаар, ЦЕГ, ХСИС-иас хамтран зохион байгуулсан Нэгдсэн Үндэсний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг бэлтгэх сургалтанд 2016.02.26-ны өдрөөс 2016.03.27-ны өдрийг дуустал ЦЕГ-ын Сургалтын төвийн харъяа Хээрийн сургалтын Нарстайн аман дахь хэсгийн байршилд байрлан 22 хоногийн турш Англи хэл, Галт зэвсэг хэрэглэх ур чадвар, Жолоодлогын ур чадвар, Цэргийн хэргийн мэдлэг, Албаны шуурхай байдлыг хангах, Холбооны бэлтгэл, Харилцааны сэтгэл зүй, Энхийг сахиулах ажиллагааны тухай ойлголт, онцлог, Компьютерийн хэрэглээ, Аминд үл хүрэх зэвсэг, Зэвсэггүйгээр тулалдах, мэх хэрэглэх, Багийн ажиллагаа зэрэг хичээлүүдээр нийт 309 цагийн сургалтанд хамрагдаж, НҮБ-аас томилогдон ирсэн шалгагчид амжилттай шалгуулж 14 алба хаагч тэнцээд байгаа бөгөөд, НҮБ-ээс эхний урилга ирээд байгаа билээ.

Иймд нийт алба хаагч та бүхэнд НҮБ-ийн энхийг сахиулах үйл ажиллагаанд өөрийн үндсэн чиг үүрэг буюу хууль сахиулах ажиллагаанд өөрийн хувцас формтой, Монгол улсын болон Цагдаагийн байгууллагын нэр хүндийг өндөрт өргөн, сурталчилах өргөн боломж нээгдэж байгаа юм.